



**"ФРОНТИЕР ЛЭНП ГРУПП" ХК-ИЙН  
2021 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа:	2021 оны 1 сарын 01- ний өдрөөс 2021 оны 12 сарын 31-ний өдөр/
үнэт цаас гаргагчийн нэр: улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: үнэт цаасны код: утасны дугаар:	“Фронттиер Лэнд Групп” Хувьцаат Компани 9010001043 MDR 976-70139949, 976-70139950
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Гадаад худалдаа, Мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээ, Менежментийн зөвлөх үйлчилгээ, Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, Программ хангамж, Мэдээллийн систем хөгжүүлэлт, Өгөгдөл цуглуулах, боловсруулах
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Компанийн 2021 оны жилийн эцсийн тайланд 2022 оны 2 сарын 9-ний өдрийн ТУЗ-ийн Аудитын Хорооноос СЗХ-нд бүртгэлтэй “Сүлд Аудит” ХХК аудит хийлгүүлхээр баталсан.
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	13 750 000,00 /мянган төгрөгөөр/
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Гүйцэтгэх захирал: Р. Сайдаброр

1	Тайлант жилийн санхүүгийн тайлан / хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Эргэлтийн хөрөнгийн дүн- <b>5824,7 сая. төг</b> Эргэлтийн бус хөрөнгийн дүн- <b>3113,4 сая. төг</b> Нийт хөрөнгийн дүн- <b>8938,1 сая.төг</b> Богино хугацаат өр төлбөрийн дүн- <b>4,4 сая төг</b> Өр төлбөрийн нийт дүн- <b>4,4 сая. төг</b> Эзэмшигчдийн өмчийн дүн- <b>13750.0 сая. төг</b> Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн- <b>8938,1 сая. төг</b>
	Орлогын тайлан	Борлуулалтын орлого (цэвэр)- <b>52,0 сая. төг</b> Нийт ашиг (алдагдал)- <b>33,9 сая. төг</b> Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)- ( <b>1310,8 сая.төг</b> ) Татварын дараах ашиг (алдагдал)- ( <b>1357,4 сая.төг</b> ) Нийт орлогын дүн- <b>52074,9 сая.төг</b>
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Өмч- <b>9252,5 сая.төг</b> Нэмж төлөгдсөн капитал- <b>3144,3 сая.төг</b> Эздийн өмчийн бусад хэсэг- <b>0.00</b> Хуримтлагдсан ашиг-( <b>3463,1 сая. төг</b> ) Нийт дүн- <b>8933,7 сая. төг</b>
	Мөнгөн гүйлгээний тайлан	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b> Мөнгөн орлогын дүн (+) <b>54,6 сая.төг</b> Мөнгөн зарлага (-) ( <b>1092,7</b> ) сая.төг Цэвэр мөнгөн гүйлгээ-( <b>1038098911,34</b> ) <b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b> Мөнгөн орлогын дүн(+) <b>3509,2 сая.төг</b> Мөнгөн зарлага(-) ( <b>562,9</b> ) сая.төг Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн- <b>2946,2 сая.төг</b> <b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ –0.00</b> Мөнгөн зарлага-( <b>0,05</b> ) сая төг Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн-( <b>0,05 сая.төг</b> ) Бүх цэвэр мөнгөн гүйлгээ- <b>1908,0 сая. төг</b>
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	<p><b>Хараат бус аудиторын тайлан</b></p> <p><b>Дүгнэлт</b></p> <p>“Сүлд Аудит” ХХК нь “Фронтнер Лэнд Групп” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, тайлант жилийн орлогын дэлгэрэгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийсэн.</p> <p>Бидний дүгнэлтээр энэхүү санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт-д нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн байна.</p> <p><b>Дүгнэлтийн Үндэслэл</b></p> <p>Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу</p>	

	<p>хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Монгол Улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигдах ёс зүйн шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай, зохистой үндэслэл болно гэж үзэж байна.</p> <p><b>Аудитын гол асуудал</b></p> <p>Аудитын гол асуудлууд гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.</p> <p><b>Бусад мэдээлэл</b></p> <p>Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.</p> <p><b>Санхүүгийн тайлангийн талаар Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага</b></p> <p>Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв шударгаар толилуулах болон залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайлан бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг удирдлагаас тодорхойлох үүрэг хариуцлага хүлээнэ.</p> <p>Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, компанийн чадамжийг үнэлж, тодруулах шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл ингэхээс өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.</p> <p><b>Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага</b></p> <p>Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгаа олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт ул үндэстэйгээр нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.</p> <p><b>Хэрэглээний хязгаарлалт</b></p> <p>Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.</p>
1.2	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл

	Тайлант хугацаанд цар тахлаас үүдэн хамтран ажиллаж буй бизнес харилцааны хувьд асуудал үүссэн. Энэ нь борлуулж буй хөрөнгийг суллаж худалдан авагчид хүлээлгэж өгөх явц удааширах мөн сул зогсолтын үеийн зардлыг түрээслэгч тал төлөх боломжгүй болох, төлбөрийн нөхцөлд хөнгөлөлт үзүүлэх цөөнгүй тохиолдол үүссэн.	
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	
	Үйл ажиллагааны орлого багассан үүнтэй холбогдуулан хэрэгцээгүй зардлыг танах, боловсон хүчний тоо хэмжээг бууруулсан.	
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	
	MT-ийн шийдлийн хувьд аялал жуулчлалын агент болон гэр камп, зочид буудлын захиалгад зориулсан B2B платформын хөгжүүлэлтийн ажил явагдсан. 2021 оны эхний улиралд бакэндийн эхний хувилбар бэлэн болж, тест болон сайжруулалтын түвшинд явагдсан. Онлайн дэлгүүрийн шийдлийн системүүдтэй анхны уулзалтууд хийж, уг системтэй хамтран ажиллах санаачлага хэвээрээ байгаа хэдий ч цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан олон улсын зах зээлд гарахад зуучлах асуудал удааширалтай байна.	
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Байхгүй
	<p>Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд</p> <ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн тайлан бэлтгэсэн байдал: Санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэгүй тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлангуудаас бүрдэж байна.</li> <li>• Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд: Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнийн өөрчлөлтийг “Арилжааны цэвэр орлого”-д тусгана.</li> <li>• Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр: Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад, арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрүүдийг багтаасан арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд бодит үнээр нь бүртгэнэ. “Арилжааны цэвэр орлого”-д бодит үнийн өөрчлөлтийг тусгана. Энэ ангилалд өөрийн үнэт цаас, өөрийн хөрөнгө болон голдуу ойрын хугацаанд буцаан худалдан авах эсвэл худалдах зорилгоор эзэмшиж байгаа үнэт цааснууд багтана. Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнээр нь тусгана. Бодит үнийн өөрчлөлтийг “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн цэвэр олз гарз” дансанд бүртгэнэ. Орж ирэх эсвэл төлөх хүүг гэрээний нөхцлийн дагуу хүүгийн орлого, зардалд хуримтлуулж, ногдол ашгийн орлогыг тус ногдол ашгийг хүртэх эрх үүссэн үед нь “Үйл ажиллагааны бусад орлого”-д бүртгэнэ.</li> </ul>	
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Байхгүй
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй	

	хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
4.	Цалин урамшууллын мэдээлэл	
	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь компаниас санхүүгийн жилийн хугацаанд 48 сая, гүйцэтгэх захирал 70 сая 500 мянган төгрөгийн цалин урамшуулал авсан байна. Гүйцэтгэх захирал албан үүргээ гүйцэтгэхэд Компаниас гадаадад зорчих зардал, томилолтын мөнгө, Бизнес уулзалт, хурал, бизнесийн түншүүдэд зориулсан хүлээн авалт, хоолны зардал, ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой гарсан бусад зардлуудыг Компани хариуцна.	
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	1	Амартүвшин. О ТУЗ-ийн гишүүн
	2	Анар.У ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
	3	Батбилэг. С ТУЗ-ийн хараат бус гишүүн
	4	Батсайхан.Д ТУЗ-ийн гишүүн
	5	Батпүрэв. Б ТУЗ-ийн гишүүн
	6	Оюунболд. Г ТУЗ-ийн гишүүн
	7	Машбат. Д ТУЗ-ийн гишүүн
	8	Тэмүүлин.Э ТУЗ-ийн дарга
	9	Шихихутаг.Б ТУЗ-ийн гишүүн
	10	Үнэнбат. Д ТУЗ-ийн хараат бус гишүүн
	ТУЗ-ын Аудитын хорооны гишүүдээр С.Батбилэг /Дарга, Хараат бус гишүүн/, Э.Тэмүүлин /Хараат бус гишүүн/, Д.Машбат /Ердийн гишүүн/ ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр Э.Тэмүүлин /Дарга, Хараат бус гишүүн/, Б.Шихихутаг /Ердийн гишүүн/, С.Батбилэг/Хараат бус гишүүн/ ТУЗ-ийн Цалин урамшууллын хорооны гишүүдээр Э.Тэмүүлин/Дарга, Хараат бус гишүүн/, Б. Шихихутаг/Ердийн гишүүн/, С.Батбилэг /Хараат бус гишүүн/	
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл	
	2021 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагааны орлогын хувьд зогсонги, хөл хорио нь бүхий л салбарт нөлөөллөө. Мөн өөрийн эзэмшлийн Реженси Резиденс дэх үл хөдлөх хөрөнгүүдийг худалдан борлуулсан. Цар тахлын эхний нөлөөллөөс шалтгаалан үл хөдлөх хөрөнгийг сонирхож байсан гадны худалдан авагч нар байхгүй, сонирхохоо болисон.Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын компаниудтай хамтран ажилласаны үр дүнд борлуулалт явагдсан.	
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/	
	Компанийн хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгө нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 13,750.0 мянган ширхэг энгийн хувьцаа байна. Компани нь нийт 248 хувьцаа эзэмшигчтэй. 5%-иас дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс, эзэмшлийн хувь доорх үзүүлэлттэй байна	
	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо ширхэг
	Mongolia Capital	3,823,744
	Discovery Fund	2,030,832
	Opportunity Fund	1,600,000
	Frontier Land Group	4,497,462
	Eastinvestor	1,000,000
		Эзлэх хувь
		27,81%
		14.77%
		11.64%
		32.71%
		7.27%
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл	

“Фронттиер Лэнд Групп” ХК нь анх “Туул Сонгино Усны Нөөц” нэртэйгээр Техникийн Усны Байгууламж, Ундны Усны Байгууламж, Усан Цэнэгт Цахилгаан Станц гэсэн гурван төслийг хэрэгжүүлэхээр 2006 оны 12-р сарын 29-ны өдөр үүсгэн байгуулагдсан. 2007 онд Монголын Хөрөнгийн Биржийн анхдагч зах зээлд хувьцаагаа гаргасан (IPO). Нийт хувьцаанаас 13.2 сая хувьцааг компани арилжаалсан ба 13 200 061 250 төгрөгийг татан төвлөрүүлсэн.

IPO хийсний дараа 2007 оны 12 дугаар сараас эхлэн компани ажилчдынхаа тоо, судалгааны ажлуудаа нэмэгдүүлж, улмаар капитал зардлууд гаргаж эхэлсэн. Тэдгээр томоохон зардлуудаас дурьдвал:

- Улаанбаатарын Сонгино Хайрхан дүүрэгт 17 га ашиглалтын талбайг 1 497 500 000 төгрөгөөр худалдан авсан
- Ундны Ус Цэвэршүүлэх Байгууламжийн зураг төслийн ажлыг гүйцэтгүүлэхээр Хятадын компанитай 505 мянган ам.долларын гэрээ байгуулсан.
- Тоног Төхөөрөмж худалдан авахад 350 сая төгрөг
- Төслийн талбайн ажлуудыг гүйцэтгэхэд (хайрга, цахилгааны шугам гэх мэт) 358 сая төгрөг
- Судалгааны ажилд 300 сая төгрөг
- 2009 оны 2 дугаар сарыг хүртэл нийт 4,588,876,575 төгрөгийг Компанийн танилцуулганд тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулсан.

2009 оны эхний хагаст шинэ удирдлага компанийн стратегийн боломжуудыг боловсруулах ажлыг гүйцэтгэсэн ба компанийн танилцуулганд тусгагдсан төслүүдийг олон улсын санхүүгийн байгууллагууд, засгийн газар болон стратегийн хөрөнгө оруулагчдын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэхийн төлөө шинээр сонгогдсон гүйцэтгэх удирдлага идэвхитэй хөөцөлдөн ажилласан. Төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон гол шалтгаан нь усны тариф бага байдаг учраас хувьцаа эзэмшигчдэд үр өгөөж муутай, баталгаатай худалдан авагчид байхгүй, төслийг хэрэгжүүлэхэд хангалттай хөрөнгө байхгүй, шаардлагатай тусгай зөвшөөрөл, патент, засгийн газрын агентлагуудтай байгуулсан гэрээ зэрэг биет бус хөрөнгүүдийг эзэмшдэггүй байсан.

Үүсгэн байгуулагчид биет бус хөрөнгөөр компанид хөрөнгө оруулалт хийхгүй байхаар шийдэж, харин тэдгээрийг ашиглан төслүүдээ компаниас хараат бусаар хэрэгжүүлэхээр шийдсэн. Үүсгэн байгуулагчид компанид хөрөнгө оруулалт хийх үүргээсээ чөлөөлөгдөхийг хүссэн. Тиймээс Компани Үүсгэн байгуулагчидтай гэрээ байгуулсан ба уг гэрээ ёсоор үүсгэн байгуулагчид үүргээсээ чөлөөлөгдөж, компанид хувьцаа эзэмших эрх цуцлагдах ёстой байсан.

2009 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хуралдсан Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Бус Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид олонхи төслүүдийн хэрэгжилтийг зогсоох, компани үүсгэн байгуулагчдын байгуулсан гэрээг цуцлахыг дэмжсэн.

Үүсгэн байгуулагчид компанийг удирдаж байх үед нийт 4 588 876 575 төгрөгийг төслүүдийн судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэх, газар, тоног төхөөрөмж худалдан авах, техникийн усны байгууламжийн зураг төслийн ажил хийлгэх болон Төсөлтэй холбоотой бусад ажлуудад зарцуулсан байдаг. Гэрээ ёсоор эдгээр хөрөнгийг компанийн санхүүгийн тайланд тусгасан бөгөөд, үүсгэн байгуулагчид төсөлдөө хөрөнгө оруулагч

олж, компанид 4 588 876 575 төгрөгөө нөхөн төлөхөөс наана хөрөнгийг үүсгэн байгуулагчдад шилжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн.

2010 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хуралдсан Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаар үнэт цаасны шинэчилсэн танилцуулгыг эхний байдлаар баталж, эцсийн байдлаар ТУЗ-д батлах эрхийг олгосон. Тус хурлаар Компанийн Дүрмийг шинэчлэн баталж, компанийн нэрийг “Монголиа Девелопмент Ресорсес” ХК болгон өөрчилсөн.

Компанийн шинэчилсэн дүрэм, үнэт цаасны танилцуулгыг Санхүүгийн Зохицуулах Хороо баталсны дагуу Компанийн үнэт цаасны арилжаа 2010 оны 7 дугаар сарын 14-ний өдрөөс сэргээгдэж, МХБ дээр компанийн хувьцаа “MDR” гэсэн шинэ үсгэн кодоор арилжаалагдаж эхэлсэн. (хуучнаар “TSU”). МДР ХК эрхлэх үйл ажиллагаагаа холдинг болгон өөрчилснөөр доорхи салбаруудад хөрөнгө оруулалт хийхээр шийдвэрлэсэн. Үүнд: газар, орон сууц, оффис, худалдаа үйлчилгээний үл хөдлөх хөрөнгүүдийг эзэмшиж байсан Үл хөдлөх хөрөнгө, барилга, барилгын материал, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц.

2010 оны 10 дугаар сараас эхлэн Компани нь төлөвлөж байсан салбарууддаа хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бөгөөд газар, орон сууц, оффис, худалдаа үйлчилгээний үл хөдлөх хөрөнгүүдийг эзэмшиж байсан.

2013 оны 11 дүгээр сарын 27-ний өдрийн ТУЗ-ийн хурлаас Төрийн Банкны ам. Долларын зээлийн өрийг тус банкны нэр дээр барьцаанд байсан орон сууцнуудыг хэсэгчлэн борлуулах замаар нэн даруй төлж барагдуулах шийдвэр гарсан. 2014 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар компани Төрийн Банкинд 1.1 сая ам.долларын зээлийн өртэй байсан. Энэхүү зээлийг 2014 оны жилийн эцсээр өрийг төлж барагдуулсан.

2015 оны 4 дүгээр сарын 30-ны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн үйл ажиллагааг шинэ тулгар зах зээлрүү нэврүүлэх зорилгоор компанийн оноосон нэрийг “Фронтинер Лэнд Групп” ХК болгож өөрчлөх шийдвэр гарсан бөгөөд компанийн нэрийг 2015 оны 8 дугаар сарын 17-нд шинэчлэн, гэрчилгээгээ авсан.

2019 оны 12 дүгээр сарын 09-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн үйл ажиллагааны чиглэлийг Мэдээлэл Технологийн салбарт үйл ажиллагаа явуулахаар шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийн дагуу 2020 оны 05 дугаар сарын 13-ний өдөр доорх үйл ажиллагааны чиглэлээр компанийн гэрчилгээг шинэчлэн авсан.

- Мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээ, үйл ажиллагаа
- Менежментийн зөвлөх үйлчилгээ
- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
- Программ хангамж, мэдээллийн систем хөгжүүлэлт
- Өгөгдөл цуглуулах, боловсруулах

2020 оны 4 дүгээр сарын 2-ний өдрийн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаар Реженс Резиденс цогцолборын оффис, худалдаа үйлчилгээний үл хөдлөх хөрөнгүүдийг уян хатан үнээр зарж борлуулан шинэ үйл ажиллагаа болон хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг санхүүжүүлэхийг их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл баталсан. Энэхүү шийдвэрийн үндсэн дээр 2020-2021 оны хооронд дээрх үл хөдлөх хөрөнгүүдийг зарж борлуулсан.

9.	Ногдол ашгийн мэдээлэл
	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн №22/02 тогтоолоор Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	Монгол улсын татварын хууль тогтоомж, заавар журмын дагуу хуулийн хугацаанд татварын тайлан гаргаж цахимаар илгээн татвараа тухай бүрд нь төлж байгаа болно.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Р.Сайдаброр	
Албан тушаал: “Фронтьер Лэнд Групп” ХК-ийн гүйцэтгэх захирал	
Гарын үсэг: .....	
(Тамга/гэмдэг)	

